

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 98. | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 13 | 426 |
| 99. | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийг томилох тухай | Дугаар 14 | 426 |
| 100. | Уул уурхайн хөгжлийн түрхороо байгуулах тухай | Дугаар 15 | 427 |
| 101. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 16 | 427 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 102. | Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлах тухай | Дугаар 171 | 428 |
| 103. | Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 172 | 438 |
| 104. | Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай | Дугаар 186 | 438 |
| 105. | Гадаадаас 2013 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай | Дугаар 192 | 441 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 106. | Сонгуулийн срөнхий хорооны 2012 оны 160 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 01 | 444 |
|------|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж байгаа тул Пүрэвийн Оюунчимэг, Жадамбын Дашдорж нарыг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг Хүний эрхийн Үндэсний Комиссын шинээр томилогдсон гишүүдийн тангараг өргөсөн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр Пүрэвийн Оюунчимэг, Нанзадын Ганбаяр нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар
 хот

Уул уурхайн хөгжлийн түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Уул уурхайн хөгжлийн бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт боловсруулах талаар Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Уул уурхайн хөгжлийн түр хороог байгуулсугай.

2.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 01 дүгээр
сарын 31-ний өдөр

Дугаар 16

Улаанбаатар
 хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Х.Тэмүүжин нараас Монгол Улсын Их Хуралд 2012 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Их дээд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар
 хот

Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Барилгын тухай хуулийн 5.1.2-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран боловсруулж баттуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Ч.Улаан, Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Батбаяр, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгах, хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагчдын зээл, тусламж, төсөлд хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Батбаяр, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт барилгын материалыг авто болон төмөр замаар тээвэрлэх, ачиж буулгах, нөөцлөх зориулалттай терминал байгуулах байршилыг тогтоож, тэдгээрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Батбаяр, Зам, тээврийн сайд А.Гансух, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

5. Хөтөлийн цементийн үйлдвэрийг шинэчлэх болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн төмрийн хүдрийг шууд ангижруулах технологийн шугамыг өргөтгөх ажлуудын явцыг эрчимжүүлж, хугацаанд нь ашиглалтад оруулах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Батбаяр, Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд тус тус даалгасугай.



6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД

Ц.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2012 оны 171 дүгээр
тогтоолын хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал”, “Барилгын материалын үйлдвэрлэлийг 2007-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” болон “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тулгуурлан энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр тусгагдсан барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр болон “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр зэрэг төсөл, зорилтыг хэрэгжүүлэх асуудлууд энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Дээрх зорилтыг хангахад манай улсын барилгын материалын үйлдвэрийн өнөөгийн хүчин чадал хүрэлцэхгүй, барилгын салбарт шаардлагатай материалын 60 гаруй хувийг импортоор хангаж байгаа нь барилгын материалын үндэсний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх арга хэмжээ авч, хувийн хэвшлийн үүсгэл санаачлагыг дэмжихийн зэрэгцээ барилгын материалын үйлдвэрийн салбарт төрөөс хөрөнгө оруулалт хийж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна.



Барилгын материалын үйлдвэрийг дэмжих энэхүү хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлснээр үндэсний үйлдвэрийн зах зээлийг хамгаалж, 2015 онд цементийн хүчин чадал жилд 4 сая тонн, арматурын хүчин чадал 300 мянган тонн-д хүрч дотоодын хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээ, сантехникийн хуванцар материал, дулаан тусгаарлах материалыг тодорхой хугацаагаар импортолж, цаашид эх орондоо бүрэн үйлдвэрлэх болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Монгол Улсын хэмжээнд хийгдэх бүтээн байгуулалт, барилгажилтын ажлыг олон улсын стандартын шаардлагад нийцсэн эх орны үйлдвэрийн, гол нэр төрлийн барилгын материалыаар хангах, энэ зорилгоор материалын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, барилгын материал үйлдвэрлэлийг түрүүлж хөгжүүлэхэд хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь зорилтуудыг тодорхойлж байна:

2.2.1 барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2. барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх;

2.2.3. барилгын материалын үйлдвэрийн түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлэх;

2.2.4. барилгын бүтээц, материал, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах;

2.2.5. барилгын бүтээц, материал, түүхий эдийн тээвэр, ложистикийн сүлжээг боловсронгуй болгох;

2.2.6. шинэ, дэвшилтэт барилгын материал, бүтээгдэхүүний стандартыг барилгын зураг төсөвт тусгаж, нэвтрүүлэх;

2.2.7. барилгын материалын үйлдвэрлэлийг хүйтний улирлаас үл хамааран жилийн турш жигд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.8. барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх.



Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

3.1.1. хувийн хэвшлийн бүтээлч идэвх, санаачлагад үндэслэсэн бодит төслийг хэрэгжүүлэх;

3.1.2. “Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын ерөнхий схем”, “Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого” зэрэг хөгжлийн стратегийн баримт бичиг, аймаг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр болон хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөтэй нягт уялдуулах;

3.1.3. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлэх, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрийн болон барилгын хаягдал зэрэг хоёр дахь түүхий эдийг боловсруулж ашиглах;

3.1.4. бүтээгдэхүүн, түүхий эдийн чанар нь олон улсын стандартын шаардлагад нийцсэн материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортын бүтээгдэхүүнийг орлуулах;

3.1.5. барилгын жинг хөнгөрүүлэх, эрчим хүчний алдагдлыг багасгах чиглэлээр барилгын материалын үйлдвэрийн технологийг үе шаттайгаар шинэчлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1. барилгын материалын үйлдвэрлэлд ашигладаг түгээмэл тархацтай ашигт малтмалын нэр томъёог тодорхой болгох, геологи хайгуулын болон олборлолт, ашиглалтад тавих шаардлага, нөхцөл, татварын орчныг боловсронгуй болгох чиглэлээр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.1.2. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан химийн хорт болон аюултай бодис импортлох, тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах талаар гарсан журамд барилгын материалын үйлдвэрийн импортын зарим түүхий эдийг хамааруулах;

4.1.3. хуучин барилга, зам, гүүрийг буулгах явцад гарах хатуу хог хаягдал болон уул уурхай, эрчим хүчний үйлдвэрийн технологийн хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулж ашиглах үйл ажиллагаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгох чиглэлээр Хог хаягдлын тухай, Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудад холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.1.4. барилга, барилгын материалын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд ажил олгогч, инженер, техникийн ажилтан, ажилчны хүлээх үүрэг, хариуцлагыг зааглан тодорхойлох чиглэлээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, “Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж мөрдх;

4.1.5. барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьчилан сэргийлэх талаар цогц арга хэмжээ авах.

4.2. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1. барилгын материалын үйлдвэрийг өргөтгөх болон шинээр барихтай холбогдсон төслийг урт хугацаатай, бага хүүтэй зээлээр санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;

4.2.2. барилга, орон сууцны өртгийг бууруулах, үнийг тогтвортжуулах арга хэмжээ авч, барилгын материалын үйлдвэрүүдэд бага хүүтэй эргэлтийн хөрөнгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгох;

4.2.3. дэвшилтэт техник, технологи бүхий барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх томоохон үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүхий эдийг импортоор оруулахаа холбогдох татвараас чөлөөлөх болон хөнгөлөлт эдлүүлэх асуудлыг судалж зохих журмын дагуу шийдвэрлэх;

4.2.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга, байгууламжид үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, барилгын материалыг ашиглах талаар тендерийн нөхцөлд тусгаж байх арга хэмжээ авах;

4.2.5. үндэсний үйлдвэрийн барилгын зарим бүтээгдэхүүний зах зээлийг хамгаалах арга хэмжээ авч, ижил төрлийн



бүтээгдэхүүний гаалийн татварыг нэмэгдүүлэх замаар импортын хэмжээг бууруулах;

4.2.6. дотоодын хөрөнгө оруулалттай дэвшилтэт техник, технологи бүхий барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

4.3. Барилгын материалын үйлдвэрийн түүхий эдийн хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1. барилгын материалын үйлдвэрлэлд ашиглагддаг түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор ердийн ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас олборлож байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зохистой тогтоох асуудлыг судалж шийдвэрлэх;

4.3.2. Улаанбаатар хот орчмоос барилгын чулуу (дайрга) бэлтгэх боломжийг судлан, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

4.3.3. уул уурхай, дэд бүтцийн томоохон төсөл болон хот, суурин газрын төлөвлөлттэй уялдуулан барилгын материалын хангамжийн асуудлыг урьдчилан төлөвлөж, геологийн хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийх асуудлыг судлан шийдвэрлэх;

4.3.4. барилгын хатуу хог хаягдал, уул уурхайн үйлдвэрийн олборлолт, ашиглалтын болон эрчим хүчиний үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад гарах үns зэрэг хог хаягдлыг боловсруулж, барилгын материал үйлдвэрлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

4.3.5. цементийн үйлдвэрлэлийг хүн амын суурьшил, барилгажилтын хэтийн төлөв, зах зээлийн эрэлт хэрэгцээ, тээвэрлэлтийн нөхцөлтэй уялдуулан төв, баруун, зүүн,.govийн бүсэд бүсчлэн байгуулах;

4.3.6. аймгийн төвд чулуу олборлох, бутлан ангилах карьер, зуурмагийн узель бүхий бетон, төмөр бетон хийц, эдлэлийн үйлдвэрлэлийг шинээр барьж байгуулах, өргөтгөл шинэчлэл хийх.

4.4. Барилгын бүтэц, материал, түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.4.1. барилгын материал, бүтээгдэхүүний олон улсын стандартыг манай орны нөхцөлд тохируулан нутагшуулах ажлыг зохион

байгуулж, барилгын материал, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх арга хэмжээ авах;

4.4.2. Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх лабораторийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, энэ чиглэлээр мэргэжлийн ажилтныг мэргэшүүлэх;

4.4.3. Барилгын үйлдвэрлэлийн чанарын хяналт, баталгаажуулалтыг шинэ түвшинд гаргах зорилгоор барилгын үйлдвэрлэлд зөвхөн тохирлын гэрчилгээтэй материал, бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч, тохирлын баталгаажуулалт хийх байгууллагын тоог нэмэгдүүлэх;

4.4.4. стандарт, техникийн нөхцөлийг шинэчлэн боловсруулах, сайжруулах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоод болон зөвлөх үйлчилгээний эрх бүхий байгууллага, инженер, техникийн ажилтныг татан оролцуулах.

4.5. Барилгын бүтээц, материал, түүхий эдийн тээвэр, ложистикийн сүлжээг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.5.1. Нийслэлийн Засаг даргатай тохиролцсоны үндсэн дээр дараах асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авна:

4.5.1.1. “Хүнд даацын авто тээврийн хэрэгсэл, техникийн өрөнхий шаардлага” (MNS 6278:2011) стандартыг хянаж, барилгын материал тээвэрлэх хүнд даацын автомашин болон зуурмагийн машины маршрутыг шинэчлэх;

4.5.1.2. Барилгын материалын тээвэрлэлт, хангамжийн сүлжээг боловсронгуй болгож, Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төмөр замын болон авто тээврийн ачих, буулгах холимог терминал байгуулж, тэдгээрийг түшиглэн барилгын материалын бөөний худалдааны төв байгуулах.

4.5.2. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээтэй уялдуулан шинээр байгуулах аж үйлдвэрийн паркын бүрэлдэхүүнд барилгын материалын үйлдвэрийг хамруулах.

4.6. Шинэ, дэвшилтэт барилгын материал, бүтээгдэхүүний стандартыг барилгын зураг төсөвт тусгаж, нэвтрүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



4.6.1. эрчим хүчиний хэмнэлттэй, угсармал, цутгамал хосолсон технологид ашиглах шинэ, дэвшилтэт барилгын материал, бүтээгдэхүүний стандарт боловсруулах, барилгын норм, дүрэмд тусган баталж мөрдүүлэх;

4.6.2. шинээр нэвтэрч байгаа барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын зураг төсөл, төсөвт тусгах.

4.7. Барилгын материалын үйлдвэрлэлийг хүйтний улирлаас үл хамааран жилийн турш жигд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.7.1. хүйтний улиралд барилгын үйлдвэрлэл болон барилгын материалын үйлдвэрийг хэвийн явуулах зорилгоор бетоны бүтцэд химийн нэмэлт хэрэглэх зэрэг шинэ технологи нэвтрүүлэх;

4.7.2. барилгын материалын бөөний худалдааны төв байгуулж, үйлдвэрийн гол нэрийн материалыг нөөцлөн хадгалах замаар үйлдвэрүүдийг жилийн турш тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

4.8. Барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт ажиллах хүний нөөц, мэргэжилтэй ажилчин бэлтгэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.8.1. барилгын материалын үйлдвэр болон лабораторид шаардлагатай байгаа мэргэжилтэй ажилчныг мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд сургаж бэлтгэх арга хэмжээ авах;

4.8.2. шинээр байгуулагдаж байгаа томоохон үйлдвэрт ажиллах инженер, техникийн ажилтныг барилгын салбарын үйлдвэрлэлд нэвтэрч байгаа шинэ техник, технологитой уялдуулан нарийн мэргэжлээр мэргэшүүлж бэлтгэх зорилгоор их, дээд сургуулиудад түргэвчилсэн сургалт зохион байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

4.8.3. барилгын салбарын ажиллагсдын тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

4.8.4. барилгын салбарын мэргэжилтэй ажилтан сургаж бэлтгэх болон ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн зэрэг бүхий л мэдээллийг багтаасан хүний нөөцийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах;

4.8.5. барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын дэргэдэх үйлдвэрлэл сургалтын төвийн болон хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг дэмжих.



Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа,
санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

5.2. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараахь хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.2.1. аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

5.2.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.2.3. төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлэх хөрөнгө;

5.2.4. Хөгжлийн банкны зээлийн хөрөнгө;

5.2.5. арилжааны банкны зээлийн хөрөнгө;

5.2.6. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

5.2.7. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;

5.2.8. дотоод, гадаадын хөрөнгө оруулалт;

5.2.9. гадаадын зээл, тусlamжийн хөрөнгө;

5.2.10. түрээс, лизингийн үйлчилгээгээр хуримтлагдсан хөрөнгө;

5.2.11. бусад.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион
байгуулалт, мониторинг

6.1. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах “Зөвлөл”-ийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнд нь холбогдох яам, Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оруулна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.2. Аймагт салбар зөвлөл ажиллах бөгөөд аймгийн Засаг дарга зөвлөлийг ахалж, бүрэлдэхүүнд нь нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод болон аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг оруулна.



6.3. Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, оролцогч байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахын зэрэгцээ хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгнө.

6.4. Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаархи тайланг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байна.

6.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гадаадын хамтын ажиллагааг бэхжүүлж, олон улсын байгууллага, мэргэжилтнээс зөвлөгөө, дэмжлэг авч ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2016 онд дараах үр дүнд хүрсэн байна:

7.1.1. Монгол Улс цемент, арматур, бетон, төмөр бетон хийц эдлэл, дулаан тусгаарлах материал, ханын дүүргэгч болон өнгөлгөөний материал зэрэг барилгын үндсэн нэр төрлийн материалын дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, барилгын материалын импортын 70-аас дээш хувийг үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах боломж бүрдсэн байна;

7.1.2. цементийн үйлдвэрлэл хуурай аргын технологид бүрэн шилжиж түлш, цахилгаан эрчим хүч, усны хэрэглээг багасгаж бүтээгдэхүүний үнийг 30-40 хувь бууруулсан байна;

7.1.3. цемент, бетон зуурмаг, хөнгөн бетоны үйлдвэрт эрчим хүчиний үйлдвэрийн хаягдал үnsийг өргөнөөр ашиглан агаарын бохирдыг багасгах, байгалийн баялгийг хэмнэх замаар барилгын материалын үйлдвэрлэл экологид ээлтэй салбар болсон байна;

7.1.4. барилгын салбарт үйлдвэржилтийн түвшин нэмэгдэж, барилгын үйлдвэрлэл улирлын хамаарлаас гарах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн байна;

7.1.5. эх орны үйлдвэрийн болон импортын барилгын материалын чанар, стандартад хяналт тавих лабораторийн сорилт шинжилгээний үндэсний тогтолцоо бий болсон байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 172

Улаанбаатар
хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

“НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын дүрэм”-ийн 7 дугаар зүйл, “Үндэсний Комиссуудын тухай” ЮНЕСКО-гийн 1978 оны Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1993 оны 18 дугаар тогтоолоор баталсан “НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага-ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын дүрэм”-ийн Гурав дахь хэсгийн 4 дүгээр зүйлд “Комиссын өдөр тутмын ажлыг хариуцлагатай нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ” гэсний дараа “Ерөнхий нарийн бичгийн даргыг Комиссын дарга томилж, чөлөөлнө” гэж нэмсүгэй.

2. Мөн дүрмийн Гурав дахь хэсгийн 1 дүгээр зүйлийн “... комиссын бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газар батална” гэснийг “... комиссын бүрэлдэхүүнийг Комиссын дарга батална” гэж, мөн хэсгийн 3 дугаар зүйлийн 1 дэх өгүүлбэр болон 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь өгүүлбэрийн “хариуцлагатай нарийн бичгийн дарга” гэснийг “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэж тус тус өөрчилсүгэй.

3. ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын ажлын албаны ажилтнуудыг албан хаагчийн хувьд Гадаад харилцааны яаманд харьялануулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Л.БОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

Гамшгаас хамгаалах улсын албадыг шинэчлэн байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.2, 17.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



1. Гамшгаас хамгаалах улсын албад, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага, албадын дарга нарыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах улсын албадын бүрэлдэхүүнийг томилон гүйцэтгэх үүргийг тогтоож, бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг улсын албадын дарга нарт, улсын албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагвад тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гамшгаас хамгаалах улсын албад байгуулах тухай” Засгийн газрын 2005 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 158 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2012 оны 186 дугаар
тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

№	Улсын албаны нэр	Түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллага	Улсын албаны дарга
1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж, мэдээлэл алба	Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
2	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэндийн сайд
3	Хүнс, хөдөө аж ахуйн алба	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
4	Түлш, эрчим хүчний алба	Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Эрчим хүчний сайд



5	Зам, тээврийн алба	Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Зам, тээврийн сайд
6	Барилга, хот байгуулалтын алба	Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Барилга, хот байгуулалтын сайд
7	Мэргэжлийн хяналтын алба	Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга
8	Хэв журам сахиулах алба	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага	Цагдаагийн ерөнхий газрын дарга
9	Сурталчилгааны алба	-	Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга
10	Мэдээлэл, харилцаа холбооны алба	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга
11	Цацрагийн аюулаас хамгаалах алба	Цөмийн энергийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Цөмийн энергийн газрын дарга
12	Уул, уурхайн алба	Уул, уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Уул уурхайн сайд
13	Хүн ам, нийгмийн хамгааллын алба	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 12 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар
хот

Гадаадаас 2013 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2013 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар тогтоосугай.
3. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах арга хэмжээ авч байхыг Эрүүл мэндийн сайд Н.Удвалд даалгасугай.
4. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Я.САНЖМЯТАВ

Засгийн газрын 2012 оны 192 дугаар

Тогтооцын хавсралт

**БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН 2013 ОНД ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ,
МЭРГЭЖИЛПТИЙН НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ**

ААН	Bynar	Caragap	F3A caragap	Тодорхойилж	Дүрмийн сан (сая төг)			
					50 хүргэл		51-100	101-500
					101-333 A33u		Нийт ажилчадын тоо	
B				Уул Уурхайн олборлолт	60	70	75	75
06				Түүхий газрын тос, байгалийн хийн олборлолт	60	70	75	75
09	099			Түүхий газрын тос, байгалийн хийн хайтуул	60	70	75	75
09	099			Уул Уурхайн олборлолтын туслахаа бусад, юйл ажиллагаа	20	25	25	25
C				БОЛОВСОРУУЛАХ ҮЙЛДВЭР	A			
10				Хүчиний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	7
13				Нэхмэлийн үйлдвэрлэл	5	6	7	7
20				Химийн, химийн төвийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8	9	10	11
23				Темерлэг бус эрээс бодисоор хийсан эндээс үйлдвэрлэл	5	9	10	12
24				Металли үйлдвэрлэл	5	5	10	10
32				Бусад болсвруулах үйлдвэрлэл	8	9	10	11
33				Машин, тоног тахеомикийг угсрах, сууринтуулах, холбогдох бусад, юйл ажиллагаа	15	15	15	15
D				Цахилгүйн, хийн, уур, алтаржуулалтын хангамж	5	6	6	7
E				Усан хангамж бокшир үс, хог хаягдлын мөнхжүүлэгт болтон цэвэрлэх юйл ажиллагаа	5	6	7	7
F				Барилга	15	15	15	15
41	410			Барилга угсралт	20	22	25	25
				Уул Уурхайн барилга угсралт	20	25	30	35
	421	4210		Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	20	25	30	35
G				Бөөний болон жилжилгэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	20	20	20	20
		45		Моторг тэврийн хэрэгслэл, мотоциклин бөөний болон жижигтэн худалдаа, засвар, үйлчилгээ	20	20	20	20



H		ТЭЭВЭР БОЛОН АГУУЛАХЫН ҮЙЛАЖИЛЛАА	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10
I		БАЙР, СҮЧИ БОЛОН ХΟОП ХҮНСЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАА												
55		Байр суурин хангах үйл ажиллагаа	5	5	10	10	10	10	10	10	10	10	10	10
56		Хоол ундаар үүлчлэх үйл ажиллагаа	10	10	10	10	10	10	10	10	10	10	10	10
M		МЭРГЭХИЙН ШИНЖЛЭХ УХДАН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАА												
72		Шинжлэх уханы эрдэм шинжилгээ, олопт, судалгааны үйл ажиллагаа	30	30	30	30	30	30	30	30	30	30	30	30
N		ЗАХИРГААНЫ БОЛОН ДЭМЖЛЭГ УЗУУГЭХ ҮЙЛ АЖИЛЛАА												
P	85	Аялал, жуулчлалын агентлаг; аяллын операторын үйл БОЛОВСРОЛ	10	15	20	15	20	25	15	20	25	20	25	25
	854	Бага болон бүрэн дунд, бусад боловсрол оптох үйл ажиллагаа	40	40	40	40	40	40	40	40	40	40	40	40
R	90	853, 8522, 8530	Техник мэргэжлийн дунд, боловсрол болон дээд боловсрол оптох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30	30	30	30	30	30
Q		ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН НИЙТМИЙН ҮЙЛ АЖИЛЛАА												
S	86	Хүний эзүүт шандийн үйл ажиллагаа	5	6	6	7	8	7	8	8	8	8	9	
	87	Оршиш сугчад, узувчад хамгийн үйл ажиллагаа	5	10	15	5	10	15	10	15	20	10	15	20
R	90	9000	ҮРПЛТ, ЗВЭРТ, ГОЛООМ, НАДАМ											
93		Бүтээгд түрүүхүүхүүрээгээний үйл ажиллагаа	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
S		Спорт, зууга цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
	95	Үйлийн болон ерхийн хэрэглээний бараа, компьтерийн зөсвэр, үйлчилгээ	5	6	6	7	7	7	8	9	8	9	9	
96	960	Хүеийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5	6	6	7	7	7	8	9	8	9	9	
U		Олон улсын БАЙГУУЛЛАА, СУУРИН ТӨЛӨӨЧИҮҮЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАА												
99	990	Олон улсын байгууллага, сурин төвлөгөөний үйл ажиллагаа	40	40	40	40	40	40	40	40	40	40	40	40
	9900	Гадаадын эх ахуйн нэлж, байгууллагын төвлөгөөчийн газар, химууллагийн үйл ажиллага явулах хувь ёсны зөвшөөрөл бүхий гадаадын төрийн бус байгууллага	25	25	25	25	25	25	25	25	25	25	25	25

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллагад 1 гадаадын иргэн байж болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2013 оны 02 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны
160 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Т.Лхагваа, Д.Наранчимэг, Д.Сугар /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Гантамир, Сонгуулийн ерөнхий хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч, тус Хорооны нарийн бичгийн дарга Б.Алтанжаргал, ахлах шинжээч Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Сонгуулийн ерөнхий хорооны 160 дугаар тогтоол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны оршин суугч, иргэн А.Гантамир Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболдод өргөн мэдүүлсэн 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойргийн дахин санал хураалтаар нэр дэвшигч Д.Арвинг Улсын Их Хурлын гишүүнд сонгогдсон шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцэд дараах мэдээллийг гаргаж байна.



1. Үндсэн хуулийн 1.2-т заалтыг зөрчсөн тухай:

Үндсэн хуулийн 1.2-т "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэсэн заалтыг зөрчсөн байна. Учир нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51.1.2-т "тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50-аас дээш хувь нь санал хураалтад оролцоогүй" бол тухайн сонгуулийг хүчингүй гэж үзэж дахин сонгууль явуулах ёстой талаар заасан байна. Гэтэл энэхүү заалт нь дахин санал хураалтад хамааруулахгүйгээр тухайн шийдвэрийг гаргасан нь буруу юм. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51.1.2-т заасан заалтыг биелүүлэхээс татгалзсан байна. Энэ нь Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

2. Үндсэн хуулийн 21.2 заалтыг зөрчсөн тухай:

Монгол Улсын Үндсэн хуулийн 21.2-т "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ ...сонгоно." Иргэд Улсын Их Хурлын гишүүнийг нийтээрээ сонгох талаар Үндсэн хуульд заасан байгаа. Иргэд нийтээрээ гэдэг нь агуулгын хувьд сонгогчдын олонх /50+1/ оролцсон байхыг хэлнэ гэж ойлгож байна. Ардчилал олонхийн зарчимд үндэслэж аливаа асуудлыг шийддэг учир энэхүү зарчим нь сонгуульд ч үйлчлэх ёстойг ийнхүү Үндсэн хуульд нийтээрээ гэсэн агуулгаар тусгасан гэж миний хувьд ойлгож байна. Улсын Их Хурлын ээлжит ч байсан дахин санал хураалт, дахин сонгууль, нөхөн сонгууль зэрэг нь бүгд л Улсын Их Хурлын гишүүнийг сонгох үндсэн утга агуулгатай учир энд нийтээрээ оролцох ёстой буюу 50+1 ирцийн нийтлэг заалт үйлчлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Иймд Сонгуулийн ерөнхий хорооны Улсын Их Хурлын даргад 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр өргөн барьсан нэр давшигч Д.Арвиныг бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч сонгогдсонд тооцсон шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шалгаж өгнө үү" гэжээ.

Хоёр. Сонгуулийн ерөнхий хорооноос 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 17 дугаар тоот албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

"Иргэн А.Гантамир Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ Сонгуулийн ерөнхий хорооны 160 дугаар тогтоол нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.2-т заасныг зөрчиж улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчсөн гэж дурдсан байна. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу



Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага мөн бөгөөд мөн хуулийн З дугаар зүйлийн 3.5-д зааснаар үйл ажиллагаандаа хууль дээдлэх зарчмыг баримтлан ажилладаг бие даасан хараат бус байгууллага юм.

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойргийн хороонд явагдсан Улсын Их Хурлын сонгуульд нийт 206836 сонгогч бүртгэгдсэнээс 131447 сонгогч буюу 63.6 хувь нь санал хураалтад оролцож санаалаа өгсөнөөр ирцийн хувьд энэ сонгууль хүчин төгөлдөр болсон. Харин тус тойргийн 3 мандатын зөвхөн хоёрт нь сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдсон.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т “Тойрот санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийн тоо тухайн тойргийн мандатын тоонд хүрээгүй бол улдсэн мандатад дахин санал хураалт явуулна” гэж заасан. Мөн хуулийн 48.6-д “... дахин санал хураалтад хамгийн олон санал авсан, улдсэн мандатын тооноос хоёр дахин илүү тооны нэр дэвшигчийг оруулах бөгөөд сонгогч зөвхөн улдсэн мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчийн телөө санал өгнө.” гэж тус тус заасан.

Иймд хуулийн дээрх заалтын дагуу тус тойргийн улдсэн 1 мандатад дахин санал хураалт явуулсан.

Нэр дэвшигч Д.Арвин дахин санал хураалтад оролцсон сонгогчдын хамгийн олон буюу 43.1 хувийн санал авч санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал авах хуулийн шаардлагыг хангасан болно.

Иймд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 49 дүгээр зүйлийн 49.3-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 160 дугаар тогтоолоор түүнийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйл нь дахин сонгууль явуулах харилцааг зохицуулсан хуулийн зохицуулалт юм. Харин Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрот явагдсан санал хураалт бол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.4-т заасны дагуу явагдсан дахин санал хураалт юм.



Дахин санал хураалт болон дахин сонгууль хоёр нь дээр дурдсанчлан ялгаатай ойлголт бөгөөд энэ харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь тусдаа зохицуулалттай юм. Иймд иргэн А.Гантамирын гаргасан мэдээллийг үндэслэлгүй гэж үзэж байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь үйл ажиллагаандaa хууль дээдлэх үндсэн зарчмыг баримталж Үндсэн хуулиар олгогдсон иргэний сонгох, сонгогдох эрхийг хангаж ажилласан болно.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэг нь тойротг явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох үндэслэлд хамааралтай байна. Сонгуулийн ерөнхий хороо 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Санал хураалтын дүнгийн тухай” 160 дугаар тогтоолоо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу гаргасан байна.

2.Сонгуулийн ерөнхий хорооны 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Санал хураалтын дүнгийн тухай” 160 дугаар тогтоол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2; Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны “Санал хураалтын дүнгийн тухай” 2012 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 160 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”; Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ ... сонгоно.” гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт

заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Ж.АМАРСАННАА

**П.ОЧИРБАТ
Т.ЛХАГВАА
Д.НАРАНЧИМЭГ
Д.СУГАР**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 14003